



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар

А/48

Амардалай

Мал угаалгын ажлыг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1, 21.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Шимэгчтэх өвчний гаралт тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор мал угаалгын ажлыг 2020 оны 07 дугаар сарын 08 ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 30 ны өдрийг хүртэл хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

Хоёр: Угаалганд хамрагдах малын тоог баг тус бүрээр хавсралтаар баталсугай.

Гурав: Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, зааврын дагуу технологит хугацаанд мал сүргийг угаалганд 100 хувь хамруулж, чанартай гүйцэтгэхийг "Дэлгэрбаяндалай" МЭҮН-ийн малын их эмч /Т.Нарангэрэл/-д даалгасугай.

Дөрөв: Монгол улсын Эмийн бүртгэлд бүртгэгдсэн чанартай эмийн бодис ашиглан, үр дүнтэй зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих, захирамжийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга /Д.Наранцэцэг/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ЦОЛМОНБААТАР

Сумын Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын
06 ний өдрийн А/75 тоот захирамжийн хавсралт



№	Багийн нэр	Угаалганд хамрагдах малын төрөл, тоо		
		Үхэр	Хонь	Ямаа
1	Баянбулаг	1658	32924	35819
2	Цахиурт	1919	34634	31624
3	Дэлгэр-Эмт	1181	26469	25001
НИЙТ		4758	94027	92444